

BOOKS
OF THE
MONGOLIAN
NOMADS



More than Eight Centuries
of Writing Mongolian

György Kara

G. Kara, *Books of the Mongolian Nomads.*
More than Eight Centuries of Writing Mongolian

First English Edition Translated from Russian by John R Krueger, Indiana University, Bloomington. Research Institute for Inner Asian Studies, 2005, vi + 1-331 + Plates I-XXX

Индиана их сургуулийн Евро-Ази судлалын хүрээлэнгийн профессор, нэрт монголч эрдэмтэн Г. Карагийн 1972 онд нийтлүүлсэн "Монгол нүүдэлчидийн ном" хэмээх номын нэмэн дэлгэрүүлсэн хоёрдох хэвлэл англи хэлээр гарлаа. Энэхүү номд эртний кидан бичигээс аваад уйгуржин монгол, дөрвөлжин үсэг, тод үсэг, соёмбо үсэг зэрэг монголчуудын удаа дараалан хэрэглэсээр ирсэн үсэг бичигийн түүх хийгээд ном хэвлэлийн баялаг уламжилалын талаар дэлгэрэнгүй үгүүлсэн нь эрдэмтэн судлаачидын анхааралыг ихэд татаж байна.

Энэхүү нэмэн дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэлд өмнөх хэвлэлийн үндэсэн агуулга хэвээр хадгалагдсан боловч зарим бөлөгийн агуулга, жишээ сэлт, зураг дүрслэл, зүүлт тайлбар, хавсралт материалууд үлэмжхэн нэмэгдсэний дээр анхны хэвлэл гарсанаас хойшхи гуч гаруй жилийн хугацаанд гарсан судалгааны шинэ материалуудаар үлэмжхэн баяжуулжээ. Мөн монголчуудын үсэг бичиг, бичигийн дурасгал, ном хэвлэлийн түүхийн талаар сүүлийн зуу гаруй жилийн дотор гарсан 850 гаруй бүтээлийг багтаасан дэлгэрэнгүй ном зүйг шинээр хийж хавсаргасан нь үнэ чухал лавламж болсон байна.

Зохиогч энд монголчуудын анхны бичиг үсэг болох киданчуудын үсэг бичигийн талаар дэлгэрэнгүй дурдаад, X зууны үед зохиосон кидан бага бичигийг тэр цагийн монгол ярианы хэлэн дээр суурилсан монголчуудын үсэг бичигийн эртний хэлбэр хэмээн үзжээ¹.

Тус зохиолын дотор согд гаралтай уйгур бичиг монголчуудын дунд анх хэрхэн дэлгэрсэн тухай асуудал энд чухал байр эзэлж байна. Үүнд холбогдох олон сонин домог, баримт мэдээ монгол, хятад, перс сурвалж бичигүүдэд тохиолддог бөгөөд уламаар түүнтэй уялдсан холбогдсон янзбүрийн үзэл онол байдаг байна. Чингис хааны үеэс ч бүр өмнө Найман, Хэрэйд аймагийн дунд уйгур бичиг, бичигийн хэл үүсэн бүрэлдэж, хэвшин тогтсоныг хожим монголчууд тэр хэвээр нь авч хэрэглэсэн гэдэг онолыг академич Б. Я. Владимирцовын дэвшүүлсэн билээ². Хожим тавиад оны үед уйгур бичиг анх найманчуудын дунд биш, харин хитанчуудын дунд дэлгэрсэн гэдэг шинэ

¹ G. Kara, *Books of the Mongolian Nomads. More than Eight Centuries of Writing Mongolian.* p. 9

² Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Л., 1929, стр. 20

таамаглалыг акад. Л. Лигети дэвшүүлсэн³ нь эрдэмтэдийн анхааралыг ихээхэн татсан юм. Ийнхүү уйгур бичиг хэзээ, хаагуур, хэрхэн дамжиж ирсэн тухайд *Найманы онол*, *Хитаны онол* гэсэн хоёр өөр онол гарч ирсэн байна. Профессор Г. Кара эдүгээ бидний үед хятад ханз үсэгээр уламжилан үлдсэн хитан хэлний зарим дурасхалуудад тохиолдож байгаа *tau*"тав", *jau* "зуу", *tau* "туулай", *šawa*: "шувуу" гэх мэт нилээд жишээнүүд дээр тулгуурлан: "Хитан хэл нь тухайн тэр үедээ нилээд эртний шинжийг хадгалж байсан монгол бичигийг бодвол одоогийн монгол аман ярианы хэлэнд илүү ойр байжээ гэдгийг эдгээр үгс харуулж байна"⁴ гэж дурдаад цааш нь: "Хэрэв монгол бичигийн хэл нь анх хитан хэлийг тэмдэглэж байсан уйгур бичигээс гаралтай гэж үзвэл тэрхүү хитан аялгуу нь эдүгээ хятад ханз үсэгээр тэмдэглэгдэн үлдсэн хитан үгсийг бодвол сонгодог монгол бичигийн хэлэнд илүү ойр байжээ гэсэн таамаглал гаргахад хүрнэ" гэсэн сонирхолтой дүгнэлт гаргасан байна⁵.

Энэхүү бүтээлийн дараагийн хэсэгт монгол үсэгийн үсэгзүйн үндэсэн бүтэц болох титэм, шүд, гэдэс, шилбэ, нум, эвэр, завьж, сүүл гэх зэрэг хорь гаруй махбодыг тодорхой жишээнүүдээр үзүүлсэнээс (82-95) гадана сэдэвийн эхний бирга тэмдэг, үгүүлбэрийн эцэсийн цэг тэмдэгүүд (97-100), хичээнгүй бичиг, таталган бичиг, эвхмэл бичигийн хэлбэр болон XIII зуунаас аваад XIX зуун хүртэлхи долоон зуугаад жилийн хугацаанд барын үсэг хэрхэн хувирч хөгжсөн байдал хийгээд ар, өвөр монгол, буриад, ойрод барын үсэгийн хэлбэр дүрсийн талаар тодорхой дурдсан байна. (104-122) Хожим профессор Ц. Шагдарсүрэн түүний бүтээлийг улам дэлгэрүүлэн монголчуудын бичиг үсэгийн тогтолцооны тухай томоохон бүтээл туурвисан билээ⁶.

Монголчуудын бичиг соёлын түүхэнд үлэмж чухал байр эзлэх үсэгийн нэг нь дөрвөлжин бичиг бөгөөд түүнийг зохиох болсон шалтгаан, бичлэгийн тогтолцооных нь талаар маргаантай асуудал олон байдаг билээ. Зохиогч энд тэдгээр асуудалуудыг хөндөн өөрийн дүгнэлтээ гаргасан байна. Тухайлвал, Юан гүрэнээс бүр өмнө зохиогдсон уйгуржин монгол бичиг байсаар байтал Хубилай хаан яагаад дөрвөлжин бичгийг шинээр зохиолгох болов гэсэн асуудалд эрдэмтэн судлаачид янзбүрээр хариулдаг. Профессор Г. Кара үүнийг монголчуудын үндэсний тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болсон өөрийн үсэг бичигтэй болох, нөгөө талаар уйгурчуудын соёлын нөлөөнөөс гарч, төвдийн соёлын хүчтэй нөлөөнд орсонтой холбон тайлбарлажээ⁷. Мөн энд дөрвөлжин үсэгийн бичлэгийн тогтолцооны талаар нилээд тодорхой дурджээ. Үүнд: "Өмнөх уйгуржин монгол бичигийн нөлөө нь зөвхөн үсгийг босоо бичих тогтолцоонд оруулсанаар барахгүй нэгэн үеийн дотор багтаж байгаа үсэгүүдийг баруун гар талаар нь холбон бичих болсон ... зэрэгээс харагдана"⁸ хэмээн дурдаад цааш нь дөрвөлжин бичигт үгийн тэргүүн бус үеийн *ö, ü* эгшигүүдийг монгол үсэгийн *ö, ü* -гийн нэгэн адил *ou, u* гэсэн нийлмэл бүтэцтэй бичдэг тухай тодорхой жишээтэйгээр дурджээ⁹. Дөрвөлжин үсэгийн бичлэгийн тогтолцоон дахь хамагийн маргаантай асуудал нь монгол хэлний хэлний урдуурхи *e* эгшигийг хоёр өөр үсэгээр ялган тэмдэглэсэн явдал юм. Профессор Г. Кара одоогоос гучаад жилийн өмнө уул хоёр үсгийг нэг фонемын хоёр хувилбарыг тэмдэглэсэн үсэг хэмээн тайлбарласан¹⁰ бөгөөд хожим Ш. Зууннаст, Хөгжилт, Хаттори нар ч мөн тэдгээр үсэгийг дээрхийн адил авианы ялгаан дээр тулгуурлан тайлбарласан билээ¹¹.

XVI-XVII зууны үеэс эхлэн монгол оронд бурханы шашины сургаал номлол, доронодахины их таван ухааны зохиол бүтээл болон хятадын сонгодог бүтээлүүдийг энэтхэг, төвөд, хятад хэлнээс

³ Лигети, Л., Рец.: Г. Д. Санжеев, *Сравнительная грамматика монгольских языков*, ч. 1, М., 1953, - ВЯ 5 (1955), 135.

⁴ Г. Кага, *Дурдсан зохиол*, 9

⁵ Г. Кага, *Дурдсан зохиол*, 28-29

⁶ Ц. Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй, тэргүүн дэвтэр* (эрт үеэс 1921 он хүртэл), УБ., 1981, 167 тал; *Монголчуудын үсэг бичгийн товчоон [Bibliotheca Mongolica: Monograph 1]*, Centre for Mongol Studies, National University of Mongolia УБ., 2001, 299 тал

⁷ Г. Кага, *Дурдсан зохиол*, 52

⁸ Г. Кага, *Дурдсан зохиол*, 54

⁹ Г. Кага, *Дурдсан зохиол*, 55

¹⁰ Д. Кара, *Книги монгольских кочевников*, стр. 29

¹¹ Junast, On Some Problems of the *e* in 'Phags-pa Script, MYu 1, 1988, 1-8; Kögjiltü, Dörbelfin üsüg-ün *e* ba *e*-yin tuqai, ÖMYS 3, 1983, 53-60; Sh. Hattori, The h'Phags-pa Letter *e* and *e* Represent One and the Same Mongolian Vowel. *Gedanke und Wirkung*. Festschrift zum 90 Geburtstag von Nikolaus Poppe, Wiesbaden, 1989, 146-151

орчуулах болсоноор монгол бичигийн хэлэнд харь хэлний олон зуун нэр томъёо, үг хэллэг орж ирсэн бөгөөд тэдгээрийн бодит дуудлагыг монгол бичиг бүрэн дүүрэн тэмдэглэж чадахгүй байсан тул харь хэлний үгийг нарийн зөв тэмдэглэх али-гали хэмээх үсэгийг нэмэн зохиосон билээ. Мөн монгол бичигийн хэл, аман ярианы хэл хоёрын зөрөө үлэмжхэн нэмэгдсэний уламаас бичигийн хэлээ ярианыхаа хэлэнд ойртуулах гэсэн хандлага гарч, түүний шууд нөлөөгөөр XVII зууны сүүлчээр "тод үсэг"-ийг зохиосон билээ. Профессор Г. Кара энэ талаар дэлгэрэнгүй дурдаад, эцэст нь: "Зая бандида 'тод үсэг'-ийг зөвхөн ойрдуудад зориулсан зохиосон бус, харин баруун, зүүн монголчуудын хэл аялгууг хоёуланг нь тэмдэглэхэд зориулсан байж болно" хэмээн тэмдэглэжээ¹².

Энэхүү номын "Монгол ном" гэсэн дараагийн бөлөгт монголчуудын ном хэвлэлийн түүхийг XIII-XIV зууны үеэс уламжилан үлдсэн чулуун ном болох хөшөө чулууны бичээсүүдээс эхлээд Ромын поп, францын вангуудад илхаадаас илгээсэн захидалууд, XVII-XVIII зууны үеийн модон барын ном хэвлэл, XX зууны үеийн бичиг захидалуудыг багтаасан өргөн хүрээтэй, баялаг материал дээр тулгуурлан ном сударын хэв загвар, зураг чимэглэл, барлах, дэвтэрлэх, сударлах арга ухааны талаар нэн тодорхой бичсэн нь энэ талаар гарсан хамагийн дэлгэрэнгүй судалгаа болно.

Монголчуудын оюуны соёлын хамагийн нандин өв болох бичиг үсэг, ном хэвлэлийн түүхийн талаар баялаг материал, өргөн мэдээлэл, шинэлэг дүгнэлт бүхий энэхүү судалгаа нь зөвхөн монголын судлал төдийгүй, дорнодахины судлалд дорвитой хувь нэмэр болсон үнэтэй бүтээл болжээ.

Д. Төмөртоогоо

¹² Г. Кара, *Дурдсан зохиол*, 149